

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ТУСЛАХ БАГШИЙН АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр: Хүүхдийн цэцэрлэг	Нэгжийн нэр:	
Албан тушаалын нэр: Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш	Албан тушаалын ангилал: Төрийн үйлчилгээний албан хаагч	Албан тушаалын зэрэглэл: ТҮБД-1
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:	
Хөдөлмөрийн нөхцөл: Бага насны олон хүүхдийн дуу чимээ, хөдөлгөөн, байнгын эрсдэлтэй нөхцөл	Онцгой нөхцөл: Шаардлагатай үед илүү цагаар ажиллах	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

<p>Албан тушаалын зорилго Хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн асран хамгаалах, хөгжүүлж хүмүүжүүлэхэд чиглэсэн бүлгийн багшийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.</p> <p>Албан тушаалын зорилт</p> <p>1.Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, дотоод дүрэм, журмыг биелүүлэн хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх.</p> <p>2.Хүүхдийн сурч, хөгжих орчны эрүүл, аюулгүй байдал, хоол, хүнсний ариун цэвэрт анхаарч, хүүхдийн хэрэгцээнд нийцсэн асрах, хамгаалах, үйл ажиллагааг гүйцэтгэж, бүлгийн багшид дэмжлэг үзүүлэх. 3.Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэцийн хөгжлийн явц, үр дүнг суралцахуйн чиглэл бүрээр багштай хамтран ажиглаж, хүүхдэд эрүүл ахуй, ариун цэвэр, осол аюулгүй байдлын дадал хэвшил олгох, өөртөө үйлчлэх чадвар эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх.</p>			
Зорилт	Албан тушаалын чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр (Шийдвэрлэх-Ш, Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Туслах-Т)
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, байгууллагын дотоод дүрэм, журам, туслах багшийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг судлах, үйл ажиллагаандаа тогтмол баримтлах;</p> <p>2.Бүлгийн багшид дэмжлэг үзүүлэхэд шаардагдах ажил мэргэжлийн чадвар, бага насны хүүхдийн онцлог, хэрэгцээг танин мэдэх, харилцах эв дүйгээ байнга дээшлүүлэх;</p> <p>3.....</p> <p>4.....</p>	<p>Байгууллагын дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах соёлыг эзэмшсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p>

<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1.Бага насны хүүхдийн эрүүл мэнд, аюул осолгүй байдлыг тогтмол хангаж, халдварт өвчин, гэмт халдлага, байгалийн гамшигт үзэгдэл зэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах;</p> <p>2.Хүүхдийг эрүүлжүүлж, чийрэгжүүлэх, зохистой дадал, хэвшил олгох сургалт, үйл ажиллагааг бие дааж болон бүлгийн багштай хамтарч чанартай зохион байгуулах;</p> <p>3.Бүлгийн эрүүл ахуй, ариун цэврийн норм, нормативыг хангаж, багш, удирдлага, холбогдох ажилтан, эмч, тогооч нарын заавар зөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;</p> <p>4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн хэлбэр, хэрэгцээнд тохирсон асрах үйлчилгээ үзүүлэх;</p> <p>5.....</p>	<p>Бага насны хүүхдийн хамгаалал, хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдал, тэдгээрт тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
----------------------------------	--	---	----------------------------

3 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Бүлгийн багшийн зохион байгуулж байгаа үндсэн сургалт, бусад үйл ажиллагааны бэлтгэл, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;</p> <p>2.Хүүхдэд ээлтэй, хүүхдийн хөгжлийг дэмжсэн, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хангахуйц сургалтын орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн хийх, боловсронгуй болгоход бүлгийн багшид туслах;</p> <p>3.Хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг байнга ажиглаж, шаардлагатай мэдээлэл, ажиглалтын үр дүнг бүлгийн багшид танилцуулах;</p> <p>4.Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх чадварыг эцэг, эх, асран хамгаалагчдад эзэмшүүлэхэд бүлгийн багшид дэмжлэг үзүүлэх;</p> <p>5.....</p> <p>.....</p>	<p>Хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалт, хөгжлийн орчин бүрдэж, хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх арга барилыг эцэг, эх, асран хамгаалагч нарт бүлгийн багштай хамтран эзэмшүүлсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой байх
Мэргэжил	
Мэргэшил	Туслах багшийн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх
Туршлага	Цэцэрлэгт дадлага хийж гүйцэтгэсэн байх
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> Бага насны хүүхдийн онцлог байдал, хөгжлийн ялгаатай хэрэгцээ, тулгамдсан асуудлыг мэдэрч, ойлгох; Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, боловсронгуй болгох; Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдад сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны хүрээнд зохих зөвлөгөө өгч, биеэр үлгэрлэх; Шаардлагатай үед бүлийн багшийг орлон ажиллах, хүүхэд хөгжүүлэх, хүмүүжүүлэх чадвартай байх; Ес суртахууны хэм хэмжээг алдалгүй сахиж, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, багш, удирдлагатай зөв зохистой харилцах; Гамшгийн үед дайчлагдах, бэлэн байдлыг хангаж ажиллах.

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<p>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</p> <ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн эрхлэгч Цэцэрлэгийн арга зүйч Бүлгийн багш

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо</p>	<p>Бусад харилцах субъект</p> <ul style="list-style-type: none"> • Бага насны хүүхэд • Цэцэрлэгийн ажилтан нар • Эцэг эх, асран хамгаалагч • Иргэд
--	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр</p>
<p>Албан тушаал:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>(Гарын үсэг) (Эцэг/эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр:</p> <p>Шийдвэрийн огноо:</p> <p>.....</p> <p>Дугаар:</p> <p>.....</p>
<p>Албан тушаалын тодорхойлолтыг батласан:</p>	
<p>Байгууллагын нэр:</p> <p>Шийдвэрийн огноо.</p> <p>Дугаар (тамга/тэмдэг)</p> <p>(Гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	